

БХИС- ИЙН СУРАЛЦАГЧДААС ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАЙ НИИ И НИ АХ, И Р ООАЙ , НОБААХ ААА НЭРЭМЖИТ ЦАЛИН, ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “БХИС-ийг 2010-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд дэвшигдсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж, суралцагчдын сурлагын чанарыг дээшлүүлэх, тэдэнд оюун ухаан, ёс суртахуун, гоо зүй, бие бялдрын өв тэгш хөгжил, хүмүүжил төлөвшүүлж, далайцтай сэтгэж, оновчтой шийдвэр гаргах чадвар, нийгэм, хамт олны өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Монгол Улсын цэргийн дүрмүүд, “БХИС-ийн дотоод журам”-ын заалт, шаардлагыг хангасан, сургалтын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, сурлага, урлаг, спортын өр өө өр онцгой амжилт гаргасан шилдэг сонсогч, оюутан, сурагчийг бүх талаар дэмжиж, тэдний амжилтыг бусдад түгээн алдаршуулахад энэхүү журмыг баримтлана.

Хоёр. Онцгой амжилт гаргасан суралцагчдыг шагнаж урамшуулах чиглэл

2.1 БХИС-ийн суралцагч, сонсогч, оюутан, сурагчдыг дараах чиглэлээр шагнаж урамшуулна.

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит шилдэгийн шилдэг сонсогчийн шагнал (Ар өй өө өө а-еэй Оаи аеэй аааааааа аааааааа тусгай журмуи ааааа);
- Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалин олгох;
- Хатанбаатар Магсаржавын нэрэмжит шагнал (жилд 1 удаа Ар гэрээс нь олгодог);
- Жанжин Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит шагнал (жилд 1 удаа Ар гэрээс нь олгодог);
- Хурандаа генерал Ж.Ёндонгийн нэрэмжит шагнал (жилд 1 удаа Ар гэрээс нь олгодог);
- Дэслэгч генерал Ш.Жадамбаагийн нэрэмжит шагнал (жилд 1 удаа Ар гэрээс нь олгодог);
- Мэргэжлийн дагуу, төрөл бүрийн олимпиад, эрдэм шинжилгээ, зохион бүтээх болон тодорхой төсөлт ажилд оролцож онцгой амжилт гаргасан суралцагчдад олгох шагнал;
- БХИС-ийн бакалаврын түвшний сургалтыг 3.8-аас дээш голч дүнтэй төгссөн сонсогч, оюутанд онцгойлох диплом, аёоааи и ааааёу гардуулж, сургуульдаа багшлуулах, магистрантурт урилгаар суралцуулах;
- 2 улирал дараалан 3.7-оос дээш голч дүнтэй суралцсан сонсогч, оюутан, сурагчдыг “Онц сурлагатан” энгэрийн тэмдгээр шагнах, гадаадын нэр хүндтэй их, дээд сургуульд суралцуулах сонгон шалгаруулалтад эхний ээлжинд оруулах;

Гурав. Нэрэмжит цалин, шагналд тодорхойлж, шалгаруулах болзол

3.1 Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалинд нэр дэвших сонсогч, оюутан нь Цэргийн командын сургууль, Цэргийн инженерийн сургууль, Цэргийн хөгжмийн сургуулийн удирдаачийн мэргэжлээр суралцагч байх бөгөөд кредит цагаа бүрэн хангаж 6 улирал дараалан 3.8-аас дээш голч дүнтэй суралцсан, сонсогч, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд тогтмол оролцож тодорхой амжилт гаргасан, нийгмийн идэвхи, санаачлагатай, ёс суртахууны зөв төлөвшил, хүмүүжилтэй, хамт олны дунд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байх нийтлэг шалгуур, шаардлага тавигдана.

3.2 Хатанбаатар Магсаржавын нэрэмжит шагналд тодорхойлогдох сонсогч, оюутан нь Цэргийн инженерийн сургуульд суралцагч ба өө аа кредит цагаа бүрэн хангаж, сүүлийн 4-өөс доошгүй улирал дараалан 3,7-оос дээш голч дүнтэй суралцсан, нийгмийн идэвхи сайтай, зөв хүмүүжил, төлөвшилтэй байх шалгуур, шаардлагыг хангасан суралцагчдаас хичээлийн жил бүр нэг удаа шалгаруулна.

3.3 Жанжин Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит шагналд тодорхойлогдох сонсогч, оюутан нь ЦКС, ЦИС, ЦХС-ийн сонсогч, оюутнууд байх бөгөөд кредит цагаа бүрэн хангасан, сүүлийн 4-өөс доошгүй улирал дараалан 3.7-оос дүү ө голч дүнтэй суралцсан, нийгмийн идэвх санаачлагатай, зөв хүмүүжил, төлөвшилтэй, өа à ò î ë ï ù õ ì ä ö ÷ ø ÿ байх шалгуур, шаардлагыг хангасан суралцагчаас хичээлийн жил бүр 1 удаа шалгаруулна.

3.4 Хурандаа генерал Ж.Ёндон, дэслэгч генерал Ш.Жадамбаа нарын нэрэмжит шагналд ЦКС-ийн Ерөнхий цэргийн команд, Төрийн захиргаа ì ү мэргэжлээр суралцдаг, кредит цагаа бүрэн хангасан, сүүлийн 4 улирал дараалан 3.7-оос дүү ө голч дүнтэй суралцсан, нийгмийн идэвхи санаачлагатай, зөв хүмүүжил, төлөвшилтэй оюутан, сонсогчийг хичээлийн жил бүр 1 удаа шалгаруулна.

Дөрөв. Шалгаруулалт явуулах

4.1 Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн шагналыг “Монгол цэргийн өдөр”-өөр жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цалинд өргөмжлөх суралцагчийг жил бүр БХИС-ийн ойн өмнө, Хатанбаатар Магсаржав, жанжин Ж.Лхагвасүрэн, хурандаа генерал Ж.Ёндон, дэслэгч генерал Ш.Жадамбаа нарын нэрэмжит шагналд жил бүрийн хичээлийн жилийн эхэнд бүрэлдэхүүн сургууль бүрээс тус бүрт 3 хүртэл хүнийг тодорхойлж нэр дэвшүүлнэ.

4.2 Шалгуур үзүүлэлтийг бүх талаар хангаж байгаа суралцагчийн материалыг бүрэлдэхүүн сургуулиуд тухайн номинацид шалгаруулалт явуулахаас тодорхойлохоос 1 сарын өмнө БХИС-ийн захиргааны зөвлөлд ирүүлнэ. Бүрдүүлэх материал:

- анкет (төрийн албан хаагчийн 1 дүгээр маягтын дагуу)
- тодорхойлолт
- бүрэлдэхүүн сургуулиас нэр дэвшүүлсэн тухай хурлын тэмдэглэл
- сурлагын дэвтэр (эх хувиар)
- эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт
- урд өмнөх шагнагдаж байсан материалын үнэмлэх, гэрчилгээ, бусад материалын хуулбар
- хамт олноос гаргасан санал (сонсогч, оюутны зөвлөл гм)

